



# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг

2025 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2025.02.24 № 33

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

422502180

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,625,298.0</u></b>	<b><u>3,408,298.0</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	3,625,298.0	3,408,298.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,625,298.0	3,408,298.0
35410	Бичиг хэргийн материал	180,000.0	-
35430	Сэлбэг хэрэгсэл	753,000.0	753,000.0
35470	Бусад хангамжийн материал	2,692,298.0	2,655,298.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>406,997,298.7</u></b>	<b><u>521,368,600.8</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	406,997,298.7	521,368,600.8
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	356,167,298.7	470,538,600.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	325,183,376.0	325,183,376.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,246,509.6)	(16,664,407.1)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,000,000.0	60,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(87,000,000.0)	(6,666,666.7)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,362,196.0	104,451,038.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(44,732,249.9)	(33,236,737.1)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,235,649.8	43,522,727.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,635,163.5)	(6,050,729.8)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	50,830,000.0	50,830,000.0
39301	Програм хангамж	1,120,000.0	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,120,000.0)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	50,830,000.0	50,830,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>410,622,596.7</u></b>	<b><u>524,776,898.8</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	=	<b><u>28,262.1</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	28,262.1
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	28,262.1
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	28,262.1
41361	Байгууллагад төлөх өглөг	-	28,262.1
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>410,622,596.7</u></b>	<b><u>524,748,636.7</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	410,622,596.7	524,748,636.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	120,685,525.7	120,685,525.7
51101	Өмч: - төрийн	50,830,000.0	50,830,000.0
51102	- хувийн	69,855,525.7	69,855,525.7
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	273,685,701.9	401,116,586.6
51210	Өмнөх үеийн үр дүн	331,218,096.6	286,990,546.6
51220	Тайлант үеийн үр дүн	(57,532,394.8)	114,126,040.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,251,369.1	2,946,524.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>410,622,596.7</u></b>	<b><u>524,776,898.8</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>935,608,200.00</b>	<b>1,316,732,237.44</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,290,100.00</b>	<b>108,290,916.44</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,290,100.00	108,290,916.44
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,290,100.00	108,090,916.44
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>930,318,100.00</b>	<b>1,208,441,321.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,264,000.00	141,141,321.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,264,000.00	141,141,321.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	842,054,100.00	1,067,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	842,054,100.00	1,067,300,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>993,140,594.76</b>	<b>1,202,294,008.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>993,140,594.76</b>	<b>1,202,294,008.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	862,914,903.53	941,079,085.94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	277,575,832.60	353,482,279.53
210101	Үндсэн цалин	277,575,832.60	199,655,758.59
210102	Нэмэгдэл	-	117,133,960.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,495,000.00
210104	Урамшуулал	-	26,197,560.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,701,983.47	44,199,909.47
210201	Тэтгэврийн даатгал	23,597,348.67	30,074,855.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,158.66	3,534,822.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,220,926.99	1,995,998.98
210204	Ажилгүйдлийн даатгал	555,231.75	1,767,411.39
210205	Эрүүл мэндийн даатгал	5,552,317.40	6,826,820.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,596,399.00	34,073,242.42
210401	Бичиг хэрэг	3,813,300.00	5,202,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,000,000.00	21,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,186,050.00	2,138,742.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,732,500.00
210408	Бараа материал акталсны зардал	7,597,049.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	246,740.00
210502	Хоол, хүнс	-	246,740.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,983,650.00	14,958,500.00
210604	Урсгал засвар	9,983,650.00	14,958,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	14,892,000.00	24,858,000.00
210702	Дотоод албан томилолт	14,892,000.00	19,858,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,000,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,603,155.00	368,958,465.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570,500.00	365,980,710.54
210803	Даатгалын үйлчилгээ	2,341,300.00	2,296,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,525.00	118,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	490,000.00
210807	Газрын төлбөр	50,830.00	50,830.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	484,561,883.46	100,301,948.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	421,931,737.70	55,516,314.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,830,000.00	9,785,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,800,145.76	34,999,734.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	130,225,691.23	261,214,922.64
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	17,000,000.00	24,715,500.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,000,000.00	24,715,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	92,415,377.66	156,811,146.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,415,377.66	128,669,825.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,141,321.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	7,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	20,810,313.57	79,688,276.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,810,313.57	79,688,276.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(57,532,394.76)</b>	<b>114,438,228.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	312,188.81
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	312,188.81
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(312,188.81)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(57,532,394.76)</b>	<b>114,126,040.05</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>930,318,100.00</b>	<b>1,208,441,321.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>930,318,100.00</b>	<b>1,208,441,321.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,264,000.00	141,141,321.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,264,000.00	141,141,321.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	842,054,100.00	1,067,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	842,054,100.00	1,067,300,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>921,413,400.00</b>	<b>1,166,849,012.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>921,413,400.00</b>	<b>1,166,849,012.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>792,276,959.77</b>	<b>905,387,349.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	278,665,084.60	353,482,279.53
210101	Үндсэн цалин	156,131,146.87	199,756,508.59
210102	Нэмэгдэл	81,206,589.73	117,133,960.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,575,000.00	10,495,000.00
210104	Урамшуулал	31,752,348.00	26,096,810.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,701,983.47	44,171,647.87
210201	Тэтгэврийн даатгал	23,597,348.67	30,045,993.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,158.66	3,534,822.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,220,926.99	1,996,599.48
210204	Ажилгүйдлийн даатгал	555,231.75	1,767,411.39
210205	Эрүүл мэндийн даатгал	5,552,317.40	6,826,820.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,184,350.00	34,177,742.42
210401	Бичиг хэрэг	3,998,300.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,000,000.00	21,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,186,050.00	2,138,742.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,039,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,968,650.00	14,958,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	985,000.00	-
210604	Урсгал засвар	9,983,650.00	14,958,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17,892,000.00	24,858,000.00
210702	Дотоод албан томилолт	14,892,000.00	19,858,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,000,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,603,155.00	368,958,465.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,570,500.00	365,980,710.54
210803	Даатгалын үйлчилгээ	2,341,300.00	2,296,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,525.00	118,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	490,000.00
210807	Газрын төлбөр	50,830.00	50,830.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	411,261,736.70	64,780,714.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	401,431,736.70	54,994,814.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,830,000.00	9,785,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>129,136,440.23</b>	<b>261,461,662.14</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	17,000,000.00	24,962,240.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,000,000.00	24,962,240.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	91,326,126.66	156,811,146.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,326,126.66	128,669,825.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,141,321.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	7,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	20,810,313.57	79,688,276.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,810,313.57	79,688,276.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,904,700.00</b>	<b>41,592,309.00</b>

	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,493,700.00</b>	<b>41,592,309.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,493,700.00</b>	<b>41,592,309.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	10,493,700.00	41,592,309.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,493,700.00	41,592,309.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(10,493,700.00)</b>	<b>(41,592,309.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(1,589,000.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	120,685,525.69	16,251,369.12	331,218,096.62	468,154,991.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>120,685,525.69</b>	<b>16,251,369.12</b>	<b>331,218,096.62</b>	468,154,991.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-57,532,394.76	-57,532,394.76
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>120,685,525.69</b>	<b>16,251,369.12</b>	<b>273,685,701.86</b>	410,622,596.67
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>120,685,525.69</b>	<b>16,251,369.12</b>	<b>273,685,701.86</b>	410,622,596.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	13,304,844.72	13,304,844.72
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>120,685,525.69</b>	<b>16,251,369.12</b>	<b>286,990,546.58</b>	<b>423,927,441.39</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-	0.00	-13,304,844.72
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	114,126,040.05	114,126,040.05
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>120,685,525.69</b>	<b>2,946,524.40</b>	<b>401,116,586.63</b>	<b>524,748,636.72</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт/хэмнэлт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,067,300,000.0</b>	<b>987,611,723.9</b>	<b>79,688,276.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,067,300,000.0</b>	<b>987,611,723.9</b>	<b>79,688,276.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,025,300,000.0</b>	<b>946,979,658.9</b>	<b>78,320,341.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>420,920,100.0</b>	<b>353,482,279.5</b>	<b>67,437,820.5</b>
210101	Үндсэн цалин	218,800,000.0	199,756,508.6	19,043,491.4
210102	Нэмэгдэл	164,760,100.0	117,133,960.9	47,626,139.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,860,000.0	10,495,000.0	3,365,000.0
210104	Урамшуулал	23,500,000.0	26,096,810.0	(2,596,810.0)
210105	Гэрээт ажлын хөлс			-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,640,100.0</b>	<b>44,171,647.9</b>	<b>8,468,452.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,100,100.0	30,045,993.8	10,054,106.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,120,000.0	3,534,822.8	(414,822.8)
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,520,000.0	1,996,599.5	523,400.5
210204	Ажилгүйдлийн даатгал	660,000.0	1,767,411.4	(1,107,411.4)
210205	Эрүүл мэндийн даатгал	6,240,000.0	6,826,820.4	(586,820.4)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,944,000.0</b>	<b>34,177,742.4</b>	<b>766,257.6</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.0	5,000,000.0	-
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.0	21,000,000.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,905,000.0	2,138,742.4	766,257.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,039,000.0	6,039,000.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,000,000.0</b>	<b>34,786,299.0</b>	<b>213,701.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	9,899,999.0	100,001.0
210602	Тавилга	10,000,000.0	9,927,800.0	72,200.0
210604	Урсгал засвар	15,000,000.0	14,958,500.0	41,500.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>25,000,000.0</b>	<b>24,858,000.0</b>	<b>142,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	20,000,000.0	19,858,000.0	142,000.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.0	5,000,000.0	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>391,795,800.0</b>	<b>390,722,975.5</b>	<b>1,072,824.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388,500,000.0	387,745,220.5	754,779.5
210803	Даатгалын үйлчилгээ	2,296,400.0	2,296,400.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	428,000.0	118,525.0	309,475.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	490,500.0	490,000.0	500.0
210807	Газрын төлбөр	58,900.0	50,830.0	8,070.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,000,000.0</b>	<b>64,780,714.5</b>	<b>219,285.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000,000.0	54,994,814.5	5,185.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.0	9,785,900.0	214,100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,000,000.0</b>	<b>40,632,065.0</b>	<b>1,367,935.0</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>25,000,000.0</b>	<b>24,962,240.0</b>	<b>37,760.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	25,000,000.0	24,962,240.0	37,760.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг			-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,000,000.0</b>	<b>15,669,825.0</b>	<b>1,330,175.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,000,000.0	8,669,825.0	1,330,175.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.0	7,000,000.0	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,067,300,000.0</b>	<b>987,611,723.9</b>	<b>79,688,276.1</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,067,300,000.0</b>	<b>987,611,723.9</b>	<b>79,688,276.1</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,067,300,000.0	987,611,723.9	79,688,276.1
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>			
610001	Төсвийн байгууллага	1	1	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>11.0</b>	<b>9.0</b>	
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7.0	5.0	-

620004	Үйлчлэх	2.0	2.0	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>11.0</b>	<b>9.0</b>	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.0	4.0	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.0	3.0	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2.0	2.0	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>141,141,321.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>141,141,321.0</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	141,141,321.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	141,141,321.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	120,000,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,141,321.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	141,141,321.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	141,141,321.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,141,321.0
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

1.1. Илрүүлэлт: АИТХ-ын даргын 2024 оны 81-р захирамжаар гадаад улсад зорчихдоо үндэсний агаарын тээврийн компаниар зорчоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ." заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

1.1. Илрүүлэлт: 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 105,085.5 мянган төгрөгийн 7 худалдан авалт, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 352,548.9 мянган төгрөгийн 16 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 дэх "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.6 дахь "худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн", 6.4.8 дахь "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв

### **Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 6,994.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд 1 алдааг аудитын явцад залруулж 4,815.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 2,179.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

Залруулсан алдаа:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийг цэвэр дүнгээр тайлагнаагүй байсан тул аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

5.2.1 Хувь хүний орлогын албан татварын тайланд 2,179.1 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4 дахь “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан

татварын хөнгөлөлт эдлүүлнэ:"заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тайланд хөнгөлөлтийг нөхөн тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт Хүлээн авсан 4,815.0 мянган бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;" 26 дугаар зүйлийн 26.1 дэх "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө." гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх, бараа материалын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэх

Дээрх албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

#### **Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

#### **Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
АИТХ	1	0			1	0	1	0	1	0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>		

#### **Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
АИТХ	2	6,994.1			1	2,179.1	1	4,815.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,994.1</b>			<b>1</b>	<b>2,179.1</b>	<b>1</b>	<b>4,815.0</b>

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/ сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
АИТХ	1						1	1

<b>Дүн</b>	<b>1</b>					<b>1</b>	<b>1</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
АИТХ	1	5,199.6			1	5,199.6	
Дүн	1	5,199.6			1	5,199.6	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>5,199.6</b>			<b>1</b>	<b>5,199.6</b>	<b>1</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	1	1			1			